


2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГАДААД АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

I. Гадаад томилолт							
Д/д	Улс, хот	Албан тушаал	Хүний тоо	Хугацаа	Зорилго	Төсөв	Үр дүн
1	Бүгд Найрамдах Сингапур	Газрын дарга	1	2022.07.06 - 2022.07.09	Албан айлчлал	-	Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүтэй албаны төлөөлөл Сингапур улсад албан ёсны айлчлал хийх үеэр нийслэл Улаанбаатар хотын авто замын сүлжээг сайжруулах, тогтвортой тээврийн менежментийг хөгжүүлэх, нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах тээврийн хэрэгслийн цахим систем нэвтрүүлэх чиглэлд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахаар 12 хэсэг, 26 заалт бүхий санамж бичгийг байгуулсан.
II. Зочид, төлөөлөгчид							
1	Сингапур	"Эс Ти Инженеринг" компани	3	2022.05.09-12	Төсөл хэрэгжүүлэх судалгаа хийх	-	Айлчлалын хүрээнд нийслэлийн хот төлөвлөлт, зохион байгуулалт, зам, тээвэртэй холбоотой чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагаа, нөхцөл байдалтай танилцан эхний шатны судалгааг хийсэн. Цаашлаад 2022-2024 онд нийслэлд хэрэгжүүлэх Замын хөдөлгөөн зохицуулалт, төлөвлөлтийн нэгдсэн систем төсөлд ашгийн бус хамтын ажиллагааны хүрээнд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах саналыг ирүүлсэн.
III. Албан уулзалт							
1	АНУ	"Оракл" компани	4	2022.02.18	Хамтран ажиллах санал танилцуулах	-	Тус компанийн зүгээс Улаанбаатар хотод сүүлийн үеийн дэвшилтэт сервер, тоног төхөөрөмж, хадгалалт, хамгаалалт, инженерийн систем, клауд үйлчилгээ, мэдээллийн систем хоорондын интеграци хийж хслбох, аюулгүй ажиллагааг хангах, орчин үеийн дэвшилтэт камерын технологийг нэвтрүүлэхэд хамтран ажиллах санал тавьж харилцан санал солилцсон.
IV. Сургалт, семинар (товч тайлангийн хамт)							
Д/д	Зохион байгуулагч	Сэдэв	Хүний тоо	Хугацаа	Албан хаагчийн нэр	Албан тушаал	Хүрсэн үр дүн
1	БНСУ, Инчон хот	ARСIСТ Дижитал удирдагчдын хөтөлбөр	1	2022.11.07 - 2022.11.11	Д.Пүрэвдорж	Системийн төлөвлөлт, технологийн шийдэл хариуцсан ахлах мэргэжилтэн	Ази номхон далайн 21 орны илтгэгч нар өөрийн улс оронд хэрэгжүүлж буй цахим хөтөлбөр болон төрийн албан хаагчдад зориулсан мэдээлэл технологийн үр дүнтэй чадварыг бий болгох талаар үзэл бодол, сайн дадал хэвшгийг хэрхэн нэвтрүүлэх талаар тушилага сүлдэлсэн.
2	Филиппин улс /цахим/	Манила хотын Тээврийн газар	5	2022.02.17	О.Чинзориг Б.Түмэнбаяр Д.Сайнхүү Ц.Батнавч Б.Ариунзаяа	Газрын дарга, Дэд бүтэц, техникийн хяналтын хэлтэс, Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс, Төслийн хэрэгжилт, зохицуулалтын хэлтэс, Хамтын ажиллагаа, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн	Филиппин улс нь 2020 оноос эхлэн RFID төхөөрөмжийг төлбөртэй хурдны зам болон орох гарах хөдөлгөөнтэй товчоодод суурилуулж төлбөр, тооцоотой холбоотой харилцааг 90 хувь цахимжуулсан. Энэ хүрээнд Манила хотод RFID төхөөрөмжийг суурилуулахад тулгарсан бэрхшээл, иргэдийн хүлээлт, хандлага, анхаарах асуудал, хууль эрх зүйн орчин зэрэг асуудалд зөвлөгөө авч харилцан санал солилцсон.
VI. Гэрээ, санамж бичиг							
Д/д	Улс, хот	Гадны байгууллагын нэр, албан тушаал	Төрөл	Огноо	Тэргүү	Гарын үсэг зурсан байгууллагын нэр, албан тушаал	Зорилго/үр дүн
1	Бүгд Найрамдах Сингапур улс	"Эс Ти Инженеринг Электроникс" компани	СБ	2022.07.08	Хамтран ажиллах	НЦХМТГ дарга О.Чинзориг, Хөдөлгөөнт байдал хариуцсан захирал Ко Чан Тиа	Улаанбаатар хотын авто замын сүлжээг сайжруулах, тогтвортой тээврийн менежментийг хөгжүүлэх, нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах, тээврийн хэрэгслийн цахим систем нэвтрүүлэх чиглэлд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахаар 12 хэсэг, 26 заалт бүхий санамж бичгийг байгуулсан.

Хянасан:  
Захиргаа, төлөвлөлт,  
санхүүгийн хэлтсийн  
дарга

 Д.Сайнхүү

Боловсруулсан:  
Хамтын ажиллагаа, гадаад  
харилцаа хариуцсан  
мэргэжилтэн

 Б.Ариунзаяа